

БАТЛАВ.

УИХ-ЫН ГИШҮҮН

Ж.ЧИНБҮРЭН

## **ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Эмнэлгийн мэргэжилтний эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн болон практик шаардлага байна. Үүнд:

#### **1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Үндсэн Хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсэгт “...өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс олон нийтийн байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх...” эрхийг баталгаатай эдлэхээр заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ийн баримт бичгийн 2.4.1.13-д “төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж санхүүжилт олгох замаар үйл ажиллагааны тасралтгүй, тогтвортой байдлыг хангах”, “2.4.8.6-д “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний ил тод байдлыг хангах, шийдвэр гаргахад ... төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх” зорилтыг Эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалт, ил тод байдлын чиглэлээр дэвшүүлсэн байна.

#### **1.2.Практик шаардлага**

Дэлхийн улс ихэнх улс орон өөрийн үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Анагаах ухааны холбоо (National Medical Association)-той байдаг ба энэхүү холбоонд тухайн оронд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй ихэнх эмнэлгийн мэргэжилтэн гишүүнээр элссэн байдаг.

Жишээ нь: Хятадын Анагаахын холбоо нь 1915 онд байгуулагдсан 677,000 гишүүнтэй, Энэтхэгийн Анагаахын холбоо нь 1928 онд байгуулагдсан, Канадын анагаахын холбоо нь 1867 үүсгэн байгуулагдсан 85,000–с илүү гишүүнтэй, Японы Анагаахын холбоо нь 1916 онд үүсгэн байгуулагдсан 172000 гишүүнтэй, Их Британийн Анагаахын холбоо нь 1832 онд байгуулагдсан 160000 гаруй гишүүнтэй, АНУ-ын Анагаах ухааны холбоо нь 1847 онд байгуулагдсан 240359 гишүүнтэй, ХБНГУ-ын Анагаахын холбоо 1947 онд байгуулагдсан 505000 гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Улс орон бүрийн мэргэжлийн нэгдсэн төрийн бус байгууллага болох Анагаах ухааны холбооны чиг үүрэг, эрхлэх үйл ажиллагаа харилцан адилгүй байдаг ч нийтлэг чиг үүрэгтэй юм. Үүнд:

- Эмнэлгийн мэргэжилтэн болон засгийн газрын хоорондын үйл ажиллагааг холбож төрийн эрүүл мэндийн бодлогыг үйл ажиллагаагаараа дамжуулан хэрэгжүүлдэг.
- Анагаах ухааны салбарын хөгжлийн гол тулгуур нь болдог
- Анагаах ухааны ёс зүйд өндөр түвшинд суралцуулж эмч-үйлчлүүлэгчийн зэрэг харилцааг хадгалах
- Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтыг эрх бүхий байгууллагатай хамтран явуулах
- Үргэлжилсэн болон багц цагийн сургалтыг зохион байгуулах
- Дотоодын болон олон улсын анагаах ухааны сургалт солилцооны үйл ажиллагааг эрхлэх
- Анагаахын шинжлэх ухааны ном сэтгүүлийг эрхлэн гаргах
- Анагаахын салбарт гарсан ололт амжилтыг урамшуулан шагнах, анагаахын судалгаа шинжилгээний үр дүнг практикт нэвтрүүлэх
- Олон нийтэд эрүүл мэндийн боловсролыг түгээх, нийгмийн эрүүл мэндийг дэмжих
- Эмнэлгийн мэргэжилтний нэр хүндийг хамгаалах, гишүүдийн хоорондоо хамтын ажиллагааг эрчимжүүлж, туршлага солилцох гүүр болж өгдөг
- Эрүүл мэндийн асуудлаар бодлогын болон тогтолцооны судалгаа явуулах
- Эмнэлгийн мэргэжилтний нийгэм, эдийн засаг, боловсрол, мэргэжлийн байдлыг хамгаалах, дэмжих
- Ажлын байран дахь ёс зүй, гэрээ, ажлын хөлс, тэтгэвэр тэтгэмж, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн үйлчилгээний талаарх зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх
- Анагаах ухаан, эрүүл мэндийн салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Хууль зүйн туслалцаа үзүүлэх зэрэг үйл ажиллагааг эрхэлдэг байна.

Дэлхийн Анагаах ухааны холбоо нь 1947 онд байгуулагдсан бөгөөд 115 орны Анагаахын холбоодыг нэгтгэсэн дэлхийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг олон улсын төрийн бус байгууллага юм. Тус холбоо нь олон улсын анагаахын сургуулиуд болон байгууллагуудтай хамтран ажиллаж, эмнэлгийн мэргэжилтэн болон үйлчлүүлэгчийн хоорондын харьцааны ёс зүйн хэм хэмжээг боловсруулж дэлхий дахинд мөрдүүлдэг. Мөн дэлхийн бүх эмнэлгийн мэргэжилтэн эрхийг хамгаалах, дэмжих, үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн эрхийг хамгаалах, тэдний хоорондын зөрчлийг арилгах, дэлхийн хэмжээнд анагаахын боловсролын хөтөлбөр болон оношилгоо, эмчилгээний стандартыг боловсруулан мөрдүүлэх, улс орон бүрийн анагаахын холбооны үйл ажиллагааг нэгтгэж дэлхийн хэмжээнд анагаах ухааны бодлогыг хэрэгжүүлж байна.

Монгол улсын хувьд Монголын анагаах ухааны холбоо (Эмнэлгийн мэргэжилтнүүдийн холбоо) үүсгэн байгуулагдаагүй байгаа бөгөөд эрүүл мэндийн салбарын олон зуун төрийн бус байгууллага нэгдсэн зохион байгуулалт байхгүй үйл ажиллагааг явуулж байна. Мэргэжлийн, нэгдсэн өөрөө удирдах ёсны, хараат бус, үндэсний байгууллагагүй учир Дэлхийн анагаах ухааны холбооны дүрмээр тус байгууллагад гишүүнчлэлээр бүртгэгдэх боломжгүй өдий хүрчээ.

Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ажлын ачаалал их байдаг тул мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олголт зарим тохиолдолд удаашрах, эмнэлгийн мэргэжилтний эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн тохиолдолд хамгаалах этгээд байхгүй эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн

дүрмийг захиргааны байгууллагаас гаргаж, хяналт тавих, хариуцлага тооцох тогтолцоо олон улсын түвшинд ажиллахгүй байгаа болно.

Иймд улсын хэмжээнд мэргэжлийн үйл ажиллагаа явуулж буй бүх эмнэлгийн мэргэжилтний төлөөллөөс сонгогдсон өөрийн чиг үүрэг, зохион байгуулалт бүхий эмнэлгийн мэргэжилтний заавал гишүүнчлэлтэй, мэргэжлийн нэр хүнд, үйл ажиллагаа, хариуцлагын нэгдсэн стандарт тогтоох, эмнэлгийн мэргэжилтний эрх ашгийг хамгаалах, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулах зорилготой эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн өөрөө удирдах ёсны нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг байгуулах шаардлага байгааг үндэслэн энэхүү хуулийн төслийг боловсрууллаа.

### **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл нь анхдагч хуулийн төслийн төрөлд хамаарах бөгөөд нийгмийн харилцааны тулгамдсан асуудлыг хуулиар зохицуулах шаардлагатай байгаа тул энэхүү хуулийн төслийг боловсруулсан.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүй үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар**

Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн бүртгэлийн хураамж, үргэлжилсэн сургалтын төлбөр, гишүүний татвар болон бусад эх үүсвэрээс санхүүжнэ.

Улсын хэмжээнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй 26.000 гаруй эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх шалгалтын сорил чанаржиж, зөвшөөрлийг тэр даруй олгож, үргэлжилсэн сургалтын чанар, хүртээмж нэмэгдэж, эмнэлгийн мэргэжилтний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчигдөхөөс хамгаалж, урьдчилан сэргийлэх, өөрсдийн төлөөллөөс бүрдсэн бие даасан, шударга ёс, тэгш эрхийн зарчимд үндэслэсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллага бий болсноор Дэлхийн анагаах ухааны холбоонд нэгдэх боломж бүрдэж, нийгэмд эерэг хандлага бий болно.

Хууль зүйн хувьд хамтын өөрийн удирдлагын бие даасан үйл ажиллагаа явуулж, хууль тогтоомжийн хүрээнд өөрсдийн үйл ажиллагааны дүрэм, журмыг батлан төрийн байгууллагад дэмжлэг үзүүлэх чиг үүргээ хэрэгжүүлж ажиллана.

### **Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, бусад хуультай нийцсэн байх бөгөөд уг хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай

болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулсан болно.

---oOo---